



МОНГОЛ УЛС  
БАЯНХОНГОР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2021 оны 10 сарын 04 өдөр

Дугаар А/620


Номгон

Г Аймгийн Онцгой комиссын штаб, Эрүүл мэндийн газрын байнгын штабын бүрэлдэхүүн, Тусгаарлан эмчлэх байранд эмчлүүлсэн иргэдийн хоолны зардалд хөрөнгө гаргах тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.3 "а", Гамшгаас хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.3, Монгол Улсын Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тогтоолоор баталсан "Аймгийн Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам"-ын 2 дугаар бүлгийн 2.1.1 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Коронавирусын халдвараас урьдчилан сэргийлэх зорилгоор гамшгаас хамгаалах өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжсэнтэй холбогдуулан Баянхонгор сумын 24 цагийн ажиллагаатай 3 пост, аймгийн Онцгой комиссын штаб, Эрүүл мэндийн газрын байнгын штабт 2021 оны 06 дугаар сараас 2021 оны 09 дүгээр сард ажилласан төрийн албан хаагч, эмнэлгийн ажилтнуудын хоолны зардал болох 26,637,700 (Хорин зургаан сая зургаан зуун гучин долоон мянга долоон зуун) төгрөгийг 13 дугаар цэцэрлэгт, Тусгаарлан эмчлүүлэх байранд эмчлүүлсэн иргэдийн хоолны зардал болох 38,169,300 (Гучин найман сая нэг зуун жаран есөн мянга гурван зуун) төгрөгийг 15 дугаар цэцэрлэгт тус тус олгож, нийт 64,807,000 /Жаран дөрвөн сая найман зуун долоо мянган/ төгрөгийг Засаг даргын нөөц хөрөнгөнөөс санхүүжүүлэхийг Засаг даргын Тамгын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч (Д.Энхжаргал)-д зөвшөөрсүгэй.

2.Энэхүү захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч (Г.Энхбаярт)-д даалгасугай.

ДАРГА  Д.МӨНХСАЙХАН

601210447